| Д/д | Санал ирүүлсэн байгууллагын нэр | № | Журмын заалтууд | Ирүүлсэн санал | Саналыг тусгасан байдал |
|---|---|---|---|---|---|
| 1 | Датаком ХХК | 1 | 3.2 дахь хэсэг | Журмын төслийн 3.2 дугаар зүйлд домэйн нэрийн бүрдлийн орон "3-аас доошгүй" гэж тусгасныг "2-оос доошгүй" болгож өөрчлөх | Саналыг тусгасан. |
| | | 2 | 4.1 дэх хэсэг | Журмын төслийн 4.1 дэх заалтыг "Үнэн, зөв бүртгэлтэй хүн, хуулийн этгээд нь MN болон МОН өргөтгөлтэй домэйн нэрийг эзэмших хүсэлтээ бүртгэгчид гаргана" болгож өөрчлөх саналтай байна. | Саналыг тусгаагүй. |
| | | 3 | 6.1.5 дахь заалт | Журмын төслийн 6.1.5 дугаар зүйл нь Домэйн нэрийн бүртгэлтэй хамааралгүй тул хасах | Саналыг тусгасан. |
| | | 4 | 8.1 дэх хэсэг | Журмын төслийн 8.1 дүгээр зүйлд "Тухайн хуулийн этгээдийг Гэрээт бүртгэгч гэж нэрлэнэ." хэмээн нэмэлтээр тодотгох | Саналыг тусгасан. |
| | | 5 | 9.8 дахь хэсэг | Журмын төслийн 9.8 дугаар зүйл дээр "Домэйн нэрийг түгжих тухай домэйн нэрийн бүртгэгч байгууллагад урьдчилан мэдэгдэнэ" гэсэн нэмэлтийг оруулах | "Бүртгэгч нь энэ журмын 9.5-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш өргөдөл, гомдлыг эцэслэн шийдвэрлэх хүртэл домэйн нэрийн бүртгэлд өөрчлөлт оруулахгүй." гэж өөрчлөн саналыг тусгасан. |
| | | 6 | 10.10.2 дахь заалт | Журмын 10 дугаар зүйлийн 10.10.2 дах заалтад дурдсан 2 жилийн хугацааны домэйн | "энэ журмын 5.6-д заасан үндэслэлээр домэйн нэр |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | нэрийн бүртгэлийн төлбөрийг аль тал хариуцах талаар тодорхой болгох эсхүл хугацааг авч хаях саналтай байна. | эзэмших эрх дуусгавар болсон." гэж өөрчлөн саналыг тусгасан. |
| | | 7 | | Журмын төсөлд 11.2 "Домэйн нэр бүртгэх, ашиглах журамд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Харилцаа Холбооны Зохицуулах Хороо болон Бүртгэгч нар харилцан зөвшилцөнө" гэсэн шинэ заалт нэмж оруулах саналтай байна. | Саналыг тусгаагүй. |
| | | 8 | 1 дүгээр зүйл | "Бүртгэгч" гэж хэн болохыг тодотгосон энэ журмын амин чухал гол заалтыг журмын 7-р зүйл эсвэл 1-р зүйл дээр заавал нэмж оруулна уу. "Олон Улсын Интернэтийн Цахим нэр, Тоон Хаягжилтын Корпорац (ICANN)-тай Монгол Улсын MN өргөтгөлтэй домэйн нэрийн үйл ажиллагаа хариуцах гэрээ байгуулсан хуулийн этгээд домэйн нэрийн бүртгэх үйл ажиллагаа эрхэлнэ. Уг этгээдийг домэйн нэрийн бүртгэгч /Цаашид "Бүртгэгч" гэх/ гэж нэрлэнэ" | Саналыг тусгасан. |
| 2 | Үндэсний дата төв УТҮГ | 9 | 3.1 дэх хэсэг | "3.1.MN, GOV.MN, EDU.MN, ORG.MN болон МОН өргөтгөлтэй домэйн нэр болон түүний дэд домэйн нэр /цаашид “Дэд домэйн нэр” гэх/-ийн иж бүрдэл нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн байна." гэж | "MN, МОН өргөтгөлтэй болон энэ журмын Хавсралт 1-д заасан дэд домэйн нэр /цаашид “Дэд домэйн нэр” гэх/-ийн иж бүрдэл нь Монгол Улсын |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | өөрчлөх | хууль тогтоомжид нийцсэн байна." гэж заасан бөгөөд Хавсралт 1-д gov.mn, edu.mn, org.mn өргөтгөлтэй домэйн нэрийг тусгасан болно. |
| | | 10 | 3.2 дахь хэсэг | "3.2.MN, GOV.MN, EDU.MN, ORG.MN өргөтгөлтэй домэйн нэрийн домэйн нь англи хэлний цагаан толгойн A-Z, a-z үсэг, 0-9 хүртэлх цифр, "-" дундуур зураас; МОН өргөтгөлтэй домэйн нэрийн домэйн нь монгол хэлний цагаан толгойн А-Я, а-я үсэг, 0-9 хүртэлх цифр, “-” дундуур зураас зэрэг 2-оос доошгүй бөгөөд 63-аас илүүгүй, эхлэл болон төгсгөл нь үсэг, эсхүл тооноос бүрдсэн нийлмэл нэр байна." гэж өөрчлөх | "MN өргөтгөлтэй болон Дэд домэйн нэрийн домэйн нь англи хэлний цагаан толгойн A-Z, a-z үсэг, 0-9 хүртэлх цифр, “-” дундуур зураас; МОН өргөтгөлтэй домэйн нэрийн дэд домэйн нь монгол цагаан толгойн А-Я, ба а-я үсэг, 0-9 хүртэлх цифр, “-” дундуур зураас зэрэг 2-оос доошгүй, 63-аас илүүгүй, эхлэл болон төгсгөл нь үсэг, эсхүл тооноос бүрдсэн нийлмэл нэр байна." гэж өөрчлөн саналыг тусгасан. |
| | | 11 | 3.3 дахь хэсэг | Энэ заалтыг хасах | Саналын дагуу хассан. |
| | | 12 | 4.1 дэх хэсэг | "4.1.Монгол Улсад оршин суугаа хаяг, бүртгэлтэй хүн, хуулийн этгээд нь MN, GOV.MN, EDU.MN, ORG.MN болон МОН өргөтгөлтэй домэйн нэрийг эзэмших хүсэлтээ бүртгэгчид гаргана." гэж өөрчлөх | "Монгол Улсын төрийн байгууллага нь gov.mn өргөтгөлтэй домэйн нэрийг эзэмших хүсэлтийг “Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам”-ын |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | хоёрдугаар зүйлд заасны дагуу “Үндэсний дата төв” УТҮГ-т гаргана." гэж заалт нэмж саналыг тусгасан. |
| | | 13 | 7.1.1 дэх заалт | "7.1.1.хоёр болон түүнээс дээш интернэтийн үйлчилгээ эрхлэгчийн сүлжээнд 2 буюу түүнээс дээ домэйн нэрийн серверийг байрлуулах;" гэж өөрчлөх | Саналыг тусгаагүй. |
| | | 14 | 7.1.2 дахь заалт | "7.1.2.Монгол Улсад байрлах MN, GOV.MN, EDU.MN, ORG.MN болон МОН өргөтгөлтэй аль нэг домэйн нэрийн бүртгэлийн өгөгдлийн сан, сервер, системтэй байх;" гэж өөрчлөх | |
| 3 | Цагдаагийн ерөнхий газар | 15 | 4.2 дахь хэсэг | "Боловсролын байгууллага" ангилал нэмэх | Саналыг тусгасан. |
| | | 16 | 4.3 дахь хэсэг | "4.3.7.ашиглалтын талаарх төлөвлөгөө; 4.3.8.серверийн техникийн хүчин чадал; 4.3.9.домэйн хаягт ашиглахаар төлөвлөгдсөн Статик АйПи /IP/ хаягийн мэдээлэл" заалтууд нэмэх | Тус санал нь журмын төсөлд домэйн нэр бүртгэгч нь домэйн нэрийг эзэмших хүсэлтийг хүлээн аваад домэйн нэрийг ашиглах үйл ажиллагааны чиглэлийг журамд заасан ангиллаар бүртгэх, серверийн нэр болон АйПи хаяг буюу домэйн нэрийн сангийн мэдээлэл олон нийтэд ил тод байх тухай тус тус туссан болно. |
| | | 17 | 4.5.5 дахь | "4.5.5.домэйн нэрийг ажлын 1 хоногт багтаан | Саналыг тусгасан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | заалт | бүртгэх бөгөөд домэйн нэр эзэмших хугацаа нь 1 жилээс доошгүй байна." гэж өөрчлөх | |
| | | 18 | 6.1 дэх хэсэг | "6.1.13.хууль зөрчсөн үйлдэл нь тогтоосон тухай хууль тогтоох эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн үйл ажиллагааг нь түдгэлзүүлэх, хандах эрхийг хязгаарлах" заалт нэмэх | 10-р бүлэгт тус зохицуулалтыг тусгасан болно. |
| 4 | Боловсролын мэдээллийн технологийн төв УТҮГ | 19 | Хавсралт 1 | Хавсралт дахь ангилалд Edu дэд домэйн нэрийг "Боловсролын байгууллага, үйл ажиллагаа" гэснийг "Боловсрол, сургалтын үйл ажиллагаа явуулдаг байгууллага, үйл ажиллагаа" гэж өөрчлөх | "Боловсрол, сургалтын байгууллага" гэж өөрчлөн саналыг тусгасан. |
| | | 20 | 7.1 дэх хэсэг | 7.1 дэх хэсэгт дараах агуулгаар заалт нэмэх "Домэйн нэрийг бүртгэгч байгууллагууд дэд домэйн нэрийн бүртгэлтэй үйлчилгээний төлбөр харилцан төлдөггүй байх" | Саналыг тусгаагүй. |
| | | 21 | 5 дугаар зүйл | "ТАВ.ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ҮНДСЭН БОЛОН ДЭД ДОМЭЙН НЭРИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, СЭРГЭЭХ, ЦУЦЛАХ" гэж өөрчлөх | "Эзэмшигчийн эрх, үүрэг, домэйн нэрийг ашиглахтай холбоотой үйл ажиллагаа" болгон өөрчлөн найруулсан. |
| | | 22 | | EDU.MN өргөтгөлтэй домэйн нэрийг эзэмших хүсэлтийг БМТТ, Эрдэмнэт сүлжээний хэлтэст гаргана гэж оруулах | Саналыг тусгасан. |
| | | 23 | 4.2 дахь хэсэг | Домэйн нэрийг ашиглах үйл ажиллагааг салбарын чиглэлээр ангилж бүртгэхэд эрдэм | Саналыг тусгасан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | шинжилгээ судалгааны хүрээлэн төвүүдийг шинжлэх ухааны чиглэл гэж оруулах | |
| | | 24 | Хавсралт 1 | Хавсралт 1-д "Монгол Улсын хуулийн этгээд, иргэн" гэснийг "Сургалтын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага, иргэн" гэж өөрчлөх | "Боловсрол, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд" гэж өөрчлөн саналыг тусгасан. |
| 5 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам | 25 | | Харилцаа холбооны тухай хуулийн хүрээнд зөвхөн бүртгэх, ашиглах харилцааг заасан тул тус журмаар бүртгэхтэй холбоотой харилцаанд домэйн нэрийг анх олгоход бүртгэх, сунгахад бүртгэх, эзэмшигч өөрчлөгдөхөд бүртгэх зэрэг харилцааг, харин ашиглахтай холбоотой харилцаанд домэйн нэрийг ашиглахыг түдгэлзүүлэх, домэйн нэрийн олголтыг цуцлах, сэргээх гэсэн харилцааг тус тус нарийвчлан зохицуулахаар журмын төслийг дахин найруулах | Журмын төслийн 4 дүгээр зүйлийн нэрийг "Домэйн нэрийг бүртгэхтэй холбоотой үйл ажиллагаа", 5 дугаар зүйлийн нэрийг "Эзэмшигчийн эрх, үүрэг, домэйн нэрийг ашиглахтай холбоотой үйл ажиллагаа" болгон өөрчлөн саналыг тусгасан. |
| | | 26 | 2.1 дэх хэсэг | Домэйн нэр биет өмч биш тул журмын төслийн 2.1-д заасан “... өмчлөгчийн эрхийг ...” гэснийг “... эзэмшигчийн эрхийг ...” гэж, “... домэйн нэрийн бүртгэлийн ...” гэснийг “... домэйн нэрийг бүртгэх, ашиглахтай холбоотой ...” гэж тус тус өөрчлөх | Саналыг тусгасан. |
| | | 27 | 2.2, 2.3 дахь хэсэг | Зүйлийн нэр, агуулгатай нийцэхгүй байх тул журмын төслийн 2.2, 2.3-ыг “Домэйн нэрийг бүртгэх | Саналыг тусгасан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | үйл ажиллагаа” хэсэгт оруулах | |
| | | 28 | 2.2 дахь хэсэг | Журмын төслийн 2.2-т заасан “хөдөлгөөний мэдээлэл” гэдэгт ямар харилцааг хамруулж ойлгохыг тодорхой болгох | "... хөдөлгөөний ..." гэснийг "... өөрчлөлтийн ..." гэж өөрчлөн саналыг тусгасан. |
| | | 29 | 3, 4 дүгээр зүйл | Журмын төслийн 3 дугаар зүйлийн нэрийг “Домэйн нэрийн бүрдэл, түүнд тавигдах шаардлага”, 4 дүгээр зүйлийн нэрийг “Домэйн нэр авах хүсэлт гаргах, бүртгэх” гэж тус тус өөрчлөх | 3 дугаар зүйлийн нэрийг саналын дагуу, 4 дүгээр зүйлийн нэрийг "Домэйн нэрийг бүртгэхтэй холбоотой үйл ажиллагаа" гэж өөрчлөн саналыг тусгасан. |
| | | 30 | 3.1 дэх хэсэг | Журмын төслийн 3.1 дэх заалтыг зохицуулсан хууль тогтоомжийг тодорхой заах, мөн “... Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн байна.” гэснийг Баримтлах зарчим хэсэгт оруулах | Саналыг тусгасан. |
| | | 31 | 3.2 дахь хэсэг | Журмын төслийн 3.2 дахь заалтыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/35 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журмын 2 дахь хэсэгтэй нийцүүлэн холбогдох зохицуулалтыг тусган оруулах | "MN өргөтгөлтэй болон Дэд домэйн нэрийн домэйн нь англи хэлний цагаан толгойн A-Z, a-z үсэг, 0-9 хүртэлх цифр, “-” дундуур зураас; МОН өргөтгөлтэй домэйн нэрийн дэд домэйн нь монгол цагаан толгойн А-Я, ба а-я үсэг, 0-9 хүртэлх цифр, “-” дундуур зураас зэрэг 2-оос доошгүй, 63-аас илүүгүй, эхлэл болон төгсгөл нь үсэг, эсхүл тооноос |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | бүрдсэн нийлмэл нэр байна." гэж өөрчлөн саналыг тусгасан бөгөөд тус заалт нь Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журмын 2 дахь хэсэгтэй нийцээгүй зохицуулалт агуулаагүй болно. |
| | | 32 | 3.4 дэх хэсэг | Журмын төслийн 3.4 дэх заалт нь бүлгийн нэртэй тохирохгүй байх тул домэйн нэр ашиглалттай холбоотой хэсэгт оруулах | Саналыг тусгасан. |
| | | 33 | | Журмын төсөлд дурдагдсан “ажлын ... хоногт” гэснийг “ажлын ... өдөрт” гэж өөрчлөх | Саналыг тусгасан. |
| | | 34 | 4.2 дахь хэсэг | Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/35 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам”-аар төрийн байгууллагад олгох домэйн нэрийн харилцааг зохицуулсан. Харин журмын төслийн 4.2-д төрийн байгууллагад олгосон домэйн нэрийг ангилан бүртгэх харилцааг заасан байх тул журам хоорондын уялдааг хангаж энэ хэсгийг дахин найруулах | "Монгол Улсын төрийн байгууллага нь gov.mn өргөтгөлтэй домэйн нэрийг эзэмших хүсэлтийг “Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам”-ын хоёрдугаар зүйлд заасны дагуу “Үндэсний дата төв” УТҮГ-т гаргана." гэж заалт нэмж саналыг тусгасан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 35 | 6.1.8 дахь заалт | Журмын төслийн 6.1.8-д заасан домэйн нэрийн нөөцийг ХХЗХ, бүртгэгч болон гэрээт бүртгэгч нь бүгд олон нийтэд мэдээлэх үүрэг хүлээсэн байна. Домэйн нэрийн олголт болон нөөцийн мэдээлэл, нэгдсэн сангийн мэдээллийн ил тод байдлыг ямар субъект хариуцахыг тодорхой болгож дахин найруулах | Журмын төсөлд ХХЗХ нь Монгол Улсын төрийн үйл ажиллагаанд ашиглах, нутаг дэвсгэрийн нэгжийг илэрхийлэх эсвэл онцлох нэршил бүхий домэйн нэрийн нөөцийн жагсаалт /цаашид “Домэйн нэрийн нөөц” гэх/-ыг үүсгэх чиг үүрэгтэй, домэйн нэр бүртгэгч нь тус домэйн нэрийг Зохицуулах хорооны зөвшөөрлийн дагуу олгоно гэж тус тус заасан нь домэйн нэрийн олголт, нөөц сангийн мэдээллийн ил тод байдлыг ХХЗХ хариуцах, зохицуулахаар тусгагдсан болно. |
| | | 36 | 6.1.12 дахь заалт | Журмын төслийн 6.1.12 дахь заалтыг хасах эсхүл холбогдох хууль тогтоомжоос ишлэл болгон оруулах | Саналын дагуу хассан. |
| | | 37 | 7.1.3 дахь заалт | Журмын төслийн 7.1.3-т заасан “Монгол Улсын үндэсний цахим мэдээллийн хадгалалт, хамгаалалт, боловсруулалтын үйлчилгээ эрхлэх үндсэн үүрэг бүхий улсын төсөвт үйлдвэрийн газар” гэснийг ““Үндэсний дата төв” УТҮГ” гэж өөрчлөх | Саналыг тусгасан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 38 | 7.1.6 дахь заалт | Журмын төслийн 7.1.6 дахь заалтыг домэйн нэр эзэмших хүсэлт гаргаж буй иргэн, хуулийн этгээдийг таньж, баталгаажуулах гэсэн агуулгаар өөрчлөн найруулах | "Танилт, нэвтрэлтийн системд холбогдсон байх" гэж өөрчлөн саналыг тусгасан. |
| | | 39 | 7.2.1 дэх заалт | Журмын төслийн 7.2.1-д домэйн нэрийг бүртгэгч байгууллага нь домэйн нэрийн ашиглалтыг хариуцахаар заасан байгааг анхаарч, дахин найруулах | "... ашиглалтыг ..." гэснийг "... хадгалалтыг ..." гэж өөрчлөн саналыг тусгасан. |
| | | 40 | 7.2.2 дахь заалт | Журмын төслийн 7.2.2-т заасан "... эрхлэн гүйцэтгэнэ." гэснийг "... хэрэгжүүлнэ." гэж өөрчлөх | Саналыг тусгасан. |
| | | 41 | 9 дүгээр зүйл | Журмын төслийн 9 дүгээр зүйлд заасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбоотой асуудлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нийцүүлэн найруулж, уг хуульд заасан заалтуудыг давхардуулан тусгахгүй байх | Журмын төслийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбоотой бүлэг нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нийцсэн бөгөөд уг хуульд заасан заалтуудыг давхардуулан тусгаагүй болно. |
| | | 42 | 9.8 дахь хэсэг | Журмын төслийн 9.8-д ямар байгууллага хориглох талаар тодорхой тусгаагүй, мөн хориглох заалт нь хууль давсан зохицуулалт байгаа тул уг заалтыг өөрчлөн найруулах | "Бүртгэгч нь энэ журмын 9.5-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш өргөдөл, гомдлыг эцэслэн шийдвэрлэх хүртэл домэйн нэрийн бүртгэлд өөрчлөлт оруулахгүй." гэж өөрчлөн саналыг тусгасан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 43 | 9.11 дэх хэсэг | Журмын төслийн 9.11-д "энэ журмын 9.17-д заасан ..." гэсэн нь буруу заалтыг ишилсэн байх байх тул засах | Саналыг тусгасан. |
| | | 44 | 9.17 дахь хэсэг | Журмын төслийн 9.17-д заалтад шийдвэрийг өргөдөл гаргагч, эзэмшигчээс гадна бүртгэгч эсхүл гэрээт бүртгэгчид мөн хүргүүлэх зохицуулалтыг тусгах | Саналыг тусгасан. |
| | | 45 | 9.16.1 дэх заалт | Журмын төслийн 9.16.1-д “... шилжүүлэх ...” гэсний дараа “..., түдгэлзүүлэх;” гэж нэмэх | Саналыг тусгасан. |
| | | 46 | 10.1 дэх хэсэг | Журмын төслийн 10.1-д заасан арга хэмжээг авах субъектийг тодорхой болгох | Журмын төсөлд эзэмшигчийг олж тогтоох боломжгүй, эсхүл холбогдох арга хэмжээг аваагүй бол Зохицуулах хороо нь энэ журмын 10.1-т заасан технологийн арга хэмжээг авна гэж заасан болно. |
| | | 47 | 10.10.2 дахь заалт | Журмын төслийн 10.10.2 нь гаргасан зөрчлийг арилгаагүй байсан ч 2 жилийн хугацаа өнгөрөхөд домэйн нэрийг сэргэхээр ойлгогдож буй тул дахин найруулах | "энэ журмын 5.6-д заасан үндэслэлээр домэйн нэр эзэмших эрх дуусгавар болсон." гэж өөрчлөн саналыг тусгасан. |
| | | 48 | | Журмын төсөлд дурдагдсан эрх бүхий байгууллагыг тодорхой болгож түүний шийдвэр, дүгнэлтүүдийг тухайлан заах | Журмын төсөлд эрх бүхий байгууллагыг хуульд заасан эрх бүхий байгууллага, түүний шийдвэр, дүгнэлтийг эрх бүхий байгууллагын хууль бус үйлдлийг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | тогтоож, холбогдох технологийн арга хэмжээг авах тухай шийдвэр, дүгнэлт гэж тус тус тусгасан болно. Мөн хуульд заасан эрх бүхий байгууллага нь Шүүх, тагнуулын байгууллага, цагдаагийн төв байгууллага, Монополын эсрэг газар, Оюуны өмчийн газар зэрэг хуульд заасан эрх бүхий байгууллага гэж зүүлт тайлбар оруулсан болно. |
| | | 49 | | Зөрчлийн хуулийн 14.1 дүгээр зүйлийн 11 дэх хэсэгт заасан Домэйн нэрийн үйлчилгээнд тавих нөхцөл, шаардлагыг ХХЗХ батлахаар заасан байна. Уг нөхцөл, шаардлагыг энэ журамд тусгах | Тус журмын төсөлд домэйн нэрийн үйлчилгээнд тавих нөхцөл, шаардлага тусгагдсан бөгөөд "Энэ журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ." гэж өөрчлөн тусгасан. |
| 6 | Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл | 50 | 5.2.3 дахь заалт | Энэхүү үүрэг нь домэйн нэр эзэмшигчийн эрхийг түдгэлзүүлэх нэг үндэслэл болохоор журмын 5.4-т заасан байгаа нь хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлах, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлыг алдагдуулах захиргааны арга хэмжээ гэж үзэж эсэргүүцэж байна. | Саналын дагуу хассан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 51 | 5.2.2 дахь заалт | Домэйн нэр эзэмшигчийн бүртгэлийн мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд ажлын 10 өдөрт багтаан шинэчлэх хүсэлтээ бүртгэгчид хүргүүлээгүй бол эрхийг түдгэлзүүлэхээр тусгасан байгаа нь бүртгэгч, гэрээт бүртгэгч, харилцааг зохицуулах чиг үүргийн байгууллагын процедурын үйл ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор бусдын хэвлэл мэдээллийн хэрэгсэл эзэмших, эрхлэх, хэвлэл нийтлэх эрхэнд халдаж болохоор журамлахыг эсэргүүцэж байна. | "бүртгэлийн мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд ажлын 30 өдөрт багтаан шинэчлэх хүсэлтээ домэйн нэр бүртгэгчид хүргүүлэх;" гэж өөрчлөн саналыг тусгасан. |
| | | 52 | 10 дугаар зүйл | Журмын 10.1 нь хуулийн хэрэгжилтийг хангах, хянах чиг үүрэг бүхий агентлаг, төрийн байгууллагын шийдвэрээр мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг хаах, хязгаарлах, эзэмших эрхийг хөндөж байгаа нь хууль зөрчсөн хэрэг болно гэж үзэж байна. | "Энэ зүйлээр зохицуулсан харилцаа нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд заасан хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хамаарахгүй болно." гэж заалт нэмж саналыг тусгасан. |